

ХЯТАДЫН ХӨРШ ОРНУУДАЙ ХАРИЛЦАХ ГАДААД ХАРИЛЦААНЫ СТРАТЕГИ БА “ХУВЬ ЗАЯАНЫ ЦОГЦ НЭГДЭЛ” ОЙЛГОЛТ

*Т.Чулуун-Эрдэнэ**

Abstract: Chinese leader Xi Jinping in his keynote speech at the Boao Forum for Asia on 7th April, 2013 noted that “Humanity lives in the same global village, we should promote a concept of Community of common destiny, following the flow of the time, maintain the right direction, unite together in times of trouble, and push forward the development of Asia and the world to a new level.” He proposed the building of the 21st century Maritime Silk Road during his visit to ASEAN Road countries and his visit to Central Asia in September 2013, respectively. “Belt and Road” has become a specific policy for China to create a community of common destiny in neighboring states. In a word, “Community of common destiny” became a new concept of global governance that has been put forward most vigorously by China in recent years, especially after Xi Jinping took office. It has become a main topic in the political field and the core concept of China’s foreign policy. In this article, the concept of Community of Common Destiny proposed by the new Chinese government is discussed. The paper addresses the basic direction of China’s foreign policy in the study of relevant publications of public documents and official media and sources. It has made reference to the literature of China’s foreign policy and conducts the research based upon document analysis.

Key words: *Community of Common Destiny, China’s foreign policy, international cooperation, Belt and Road*

1. Хятадын хөрш орнуудтай харилцах гадаад харилцааны чиг хандлага

2013 оны 4 сарын 7 өдөр Хятад улсын дарга Ши Жиньпин Боаогийн Азийн Форумын Хуралдаан дээр “Хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй, улс орнууд нэг дэлхий дээр оршиж байна. Хамтын хөгжил бол тогтвортой хөгжлийн чухал үндэс.....бид нэгэн бөмбөрцөг хотхон дээр аж төрөхдөө нийтлэг хувь заяаны цогц нэгдэл (命运共同体)-ийн үзэл ухамсрыг бат бэх бүрдүүлж, цаг үеийн чиг урсгалтай хөл нийлүүлэн, зөв чиг шугам баримтлан, жаргал зовлонгоо хуваалцан, Ази тив болон дэлхийн хөгжил шинэ шатанд дэвшихэд тус дөхөм үзүүлэх ёстой” хэмээн онцлон тэмдэглэв. Тэрбээр мөн оны 10 сард АСЕАН-ы улс орнуудад айлчлах үеэрээ

* ХИС-ийн Гадаад хэлний тэнхимийн багш, Доктор (Ph.d)

“21-р зууны далайн торгоны зам”-ийг бүтээн байгуулах талаар анхлан дэвшүүлж, мөн 9 сард Төв Азид айлчлахдаа “Торгоны замын эдийн засгийн бүс” буюу “Нэг бүс нэг зам”-ийг дэвшүүлсэн билээ. Ийнхүү “Нэг бүс нэг зам” нь хятадын зүгээс хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдлийг цогцлоох бодит бодлого болов.

Нэг үгээр хэлбэл “Хувь заяаны цогц нэгдэл” нь сүүлийн жилүүдэд ялангуяа Ши Жиньпин засгийн эрхийг авснаас хойш хятад улсын зүгээс ихээхэн хүчин чармайлт гарган дэвшүүлж буй олон улсын асуудлыг удирдан засах лугаа холбоотой шинэ ойлголт бөгөөд улс төрийн хүрээний халуун сэдэв, хятадын гадаад харилцааны гол цөм ойлголт хэдийн болоод байна.

2012 оны 12 сарын 5-нд Ши Жиньпин өөрийн улсад суугаа гадаад улс орнуудын мэргэжилтэдтэй хийсэн ажлын уулзалтын үеэр “Хүн төрөлхтөн ‘би байваас та байна, та байваас би байна’” гэсэн хувь заяаны цогц нэгдэл болон бүрэлдэж, эрх ашиг дээд түвшинд харилцан нэвчиж, бие биенээсээ харилцан хамааралтай болж байна”² хэмээн анхлан хэлснээс хойш өнөөдрийн хүртэл аливаа том, жижиг форум, уулзалт, хуралдаан бүрт хувь заяаны цогц нэгдэлийн тухай олонтаа дэвшүүлсээр ирэв. Хятадын шинэ засгийн газраас дэвшүүлсэн энэхүү “хувь заяаны цогц нэгдэл” ойлголтыг авч үзэхдээ хятадын гадаад харилцааны стратегийн үндсэн чиг баримжааны талаар эхлэн авч үзэх нь зүйтэй юм.

1997 онд хятад улс анх удаа “Олон улсын нийгэмд хариуцлагатай их гүрэн байх” стратегийг тунхагласнаас хойш хятадын олон улсад хариуцлагатай байх хүсэл эрмэлзэл хийгээд хүчин чадал тасралтгүй өсч, олон улсын нийгмийн тогтолцоонд нэвтэрч, дэлхийн хэмжээнд дуу хоолойгоо хүргэхээр чармайж эхэлсэн бөгөөд тухайн онд Зүүн өмнөд Азид дэгдсэн санхүүгийн хямралын үеэр хятад улс юань-ий ханшийг бууруулахгүй байх чиг бодлогыг баримтлах зэрэг арга хэмжээ авсан нь Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн тогтвортой байдалд сайнаар нөлөөлж, Хятад улсыг тус бүс нутагт үзүүлэх нөлөө, байр суурийг илэрхий нэмэгдүүлсэн юм³.

1997 онд ХКН-ын 15-р их хуралд гадаад харилцааны бодлогоо илүү тодорхой гаргасан ба жишээ нь Жян Зөминь “Сайн хөршийн найрсаг харилцаа бол манай орны тууштай баримталсаар ирсэн бодлого бөгөөд хэзээ ч хувирч өөрчлөгдөхгүй; манай улсын хийгээд хөрш орнуудын хооронд оршиж буй маргаантай асуудлуудыг энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах байдал доор авч үзэн, найрсагаар хэлэлцэн зөвшилцөх замаар шийдвэрлэх хэрэгтэй. Нэгэн мөчид шийдвэрлэж чадахгүй асуудал байх аваас түүнийг хэсэг хугацаанд хойш тавьж, ижил зүйлээ эрэлхийлж, эндүү зөрөөтэй талаа хэвээр хадгалах болно” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг⁴. Цаашлаад намын 16-р их хурлын ажлын тайланд: “Сайн хөршийн найрсаг харилцааг улам бэхжүүлж, сайн хөрш, түнш хөршийн харилцааг

² 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2017.

³ Thomas Lum, et al, China’s “Soft Power” in Southeast Asia (Washington, D.C.: U.S. Senate Committee of Foreign Relations, 2008), p.2

⁴ 高举邓小平理论伟大旗帜, 把建设有中国特色社会主义事业全面推向二十一世纪(2) —江泽民在中国共产党第十五次全国代表大会上的报告, 人民网, 1997年9月12日; <http://www.71.cn/2018/0129/984329.shtml>

баримталж, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хөрш зэргэлдээ улс орнуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагаагаа сайжруулах”⁵ –ын чухалыг улам лавшруулан өгүүлэв.

Түүнчлэн Хятад улс даян дэлхийн аюулгүй байдлыг баталгаажуулах нь даян дэлхийн эрх ашгийн цогц нэдлийг байгуулах зайлшгүй нөхцөл хэмээн үзэж байна. 2014 онд Ши Жипинь “Аюулгүй байдлын үзэл баримтлалыг идэвхтэй цогцлоож, аюулгүй хамтын ажиллагааны шинэ байдлыг хамтдаа бүтээцгээ” хэмээх хуралдаанд хэлсэн үгэндээ “аюулгүй байдал, хамтын ажиллагааны их хэргийг хамтдаа хэлэлцэн, урт хугацааны тогтвортой, аюулгүй байдлын сайн бодлогыг хамтдаа төлөвлөн, хөгжил цэцэглэлтийн их үйлсэд хамтдаа туслах” тухай дэвшүүлэхийн зэрэгцээ “Нийтлэг, цогц, хамтын ажиллагааны, тогтвортой Азийн аюулгүй байдлыг хангах” үзэл баримтлалыг дэвшүүлэхийн чухалтайг дэвшүүлэв⁶. Мөн дэлхийн улс орон бүрийн хамтын хөгжлийг биелүүлэхийн зэрэгцээ дэлхийн аюулгүй байдлыг хамтдаа чармайн хамгаалж, баталгаажуулна гэдэг бол даян дэлхийн эрх ашгийг хамгаалан, биелүүлж, хүн төрөлхтөний хувь заяаны цогц нэгдлийн мөн чанарыг бий болгох шаардлага юм⁷ хэмээн онцолсон бол АСЕАН-ий бүс нутгийн форумд “аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал”-ыг дэвшүүлэн, “харилцан итгэлтэй, харилцан ашигтай, эрх тэгш, уялдуулан зохицуулсан аюулгүй байдал”-ыг гадаад харилцааны зарчмаа болгов⁸. Энэ Хятадын бүс нутгийн хийгээд олон улсын хэрэгт илүү боловсронгуй, илүү өөртөө итгэлтэй, илүү бүтээлч шинжтэй арга барилыг ашиглаж эхэлснийг харуулж байна⁹.

Хятад улс 2003 оноос “сайн хөрш байх, сайн түнш байх” хөрш орнуудын гадаад харилцааны бодлогыг дэвшүүлж, “сайн хөрш, амгалан хөрш, баян хөрш байх” үзэл бодлыг баримтлахын зэрэгцээ “энх тайван, аюулгүй, хамтын ажиллагаа, хөгжил цэцэглэл”-ийг бодлогын зорилгоо болгож, бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхийлэн урагшлуулж, түүнчлэн олон улсын тогтолцоонд аажмаар нэвтэрч, алгуур алгуураар “зохиролт дэлхий” үзэл баримтлалыг дэвшүүлж, олон талт механизмаар дамжуулан, асуудлыг харилцан ашигтай, хамтран ажиллах, хэлэлцэх зөвшилцөх замаар хөгжлийн төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэхийн чухалтайг онцолсон байна. 2005 оны 4 сард Ху Жинтао Ази, Африкийн улс орнуудад “өөр өөр соёл иргэншлүүд энх тайвнаар зэрэгцэн оршиж, эрх тэгшээр дуу хоолойгоо өргөж, цэцэглэн хөгжих явдлыг урагшлуулж, нэгэн зохиролт дэлхийг хамтдаа бий болгох”¹⁰ хэрэгтэй хэмээн заан хэлснээр, зохиролт дэлхий хэмээх хэллэг анх удаа нийгэд сонсогджээ.

Энэхүү “зохиролт дэлхий үзэл баримтлал”-ын үндсэн төлөвлөлт доор Хятад

⁵ 江泽民同志在党的十六大上所作报告全文, 2002年11月18日, https://www.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zyjh_674906/t10855.shtml

⁶ 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2014.

⁷ 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2017

⁸ Мөн тэнд

⁹ Evan S. Medeiros and M. Taylor Fravel, “China’s New Diplomacy,” *Foreign Affairs*, 82:6 (2003), p.22.

¹⁰ 胡锦涛在亚非峰会上的讲话全文, 新华网, 2005年4月22日; <http://news.sina.com.cn/w/2005-04-22/18355725062s.shtml>

улс хөрш зэргэлдээ улс орнууддаа “сайн хөршийн гадаад харилцаа”-г удирдлага болгосон бодлогыг авч хэрэгжүүлж, чиг бодлогын хувьд юуны өмнө “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим”(тусгаар тогтнол бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн оршихыг)-аас эхэлж, хятад улсын эдийн засгийг сайжруулахад тустай энх тайван олон улсын орчныг бүрдүүлэх; дараа нь “бүс нутгийн хамтын ажиллагааны таван зарчим” (харилцан хүндэтгэх, эрх тэгш харилцан ашигтай, харилцан нээлттэй байх, хамтдаа цэцэглэн хөгжих, харилцан зөвшилцөж нэгдмэл ойлголтод хүрэх)-ыг баримталж, асуудлыг түр хойш нь тавих нөхцөл доор түүхийн улбаатай үлдсэн асуудлыг хэлэлцэн зөвшилцөж шийдвэрлэх; эцэст нь бүс нутгийн нэгдлийг зангидах явдлыг дэмжих хийгээд “гурван хөрш”-ийн зарчмыг ухаарч ойлгон, “их гүрнийг тэргүүнд тавьж, хөрш зэргэлдээ орнуудыг голлох” үндэс болгож, Зүүн Азийг манлайлах байр сууриа бэхжүүлэх бодлого баримтлан¹¹ ажилласан байна. Харин Ши Инхун профессор Хятадын гадаад харилцааны бодлогын тухай: “Миний бодоход гадаад харилцааны бодлогодоо бид сүүлийн жилүүдэд маш том алдаа хийсэн нь юу гэвэл бид зөвхөн Хятад, Америкийн харилцааг чухлын доторхи чухал байранд тавьж, харин Хятад улс нэгэн хүчирхэг гүрэн болохын хувьд зөвхөн Америкийг чухлын доторхи чухалд тооцох бус стратегийн салбарт гадаад харилцааны бодлогын салбарт бас нэгэн чухлын чухал зүйл нь ээдрээ төвөгтэй ч Хятадын хувьд маш чухал хөрш орнуудын харилцаа байдаг шүү гэдгээ мартсан явдал юм”¹² хэмээн эргэцүүлэн хэлсэн байдаг. Ши Жиньпин засгийн эрхийг барьснаас хойшхи хоёр жилийн хугацаанд хөрш орнуудтай харилцах гадаад бодлого болон их гүрэнтэй харилцах гадаад бодлогыг ижил тэнцүү байр сууринд тавьж, Хятадын гадаад харилцааны бодлогын стратеги дахь “их гүрний гадаад харилцаа” хэмээх нэг хүндийн төвөөс “их гүрний гадаад харилцаа ба хөрш орнуудын гадаад харилцаа” гэсэн хоёр талт хүндийн төвт зохицуулалт хийв.

Түүнчлэн 2007 онд ХКН-ын гол удирдагчдын нэг Вү Бангуо “улс төрийн хувьд эв зохиролтойгоор оршин тогтнож, эдийн засгийн хувьд эрх тэгш харилцан ашигтай, аюулгүй байдлын хувьд харилцан итгэлцэж, хамтран ажилласан, соёлын хувьд харилцаа солилцоо харилцан хүртээлтэй” “шинэ хэлбэрийн ази”-ийн бүтцийг байгуулах¹³ тухай дэвшүүлж, мөн 2014 онд Ли Көчянь “Азийн эрх ашгийн цогц нэгдэл, Азийн хувь заяаны цогц нэгдэл, Азийн хариуцлагын цогц нэгдэл”-ийг байгуулах саналыг дэвшүүлсэн¹⁴ нь дэлхий нийтийн анхаарлыг ихэд татжээ. Сүүлийн жилүүдэд Хятад улс ийнхүү “Ази”-ийг төвлөсөн хөгжлийн хийгээд аюулгүй байдлын үзэл баримтлалын тухай ихэд дэвшүүлэх болов.

¹¹ Robert G. Sutter, *Chinese Foreign Relations: Power and Policy since the Cold War* (Maryland: Rowman & Littlefield, Inc., 2008), p.261.

¹² Лью Шипин, орчуулсан Т.Чулуун-Эрдэнэ, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй ба арга зам, УБ, 2020 он, Соёмбо хэвлэлийн газар.

¹³ 中国提出新型亚洲引起共鸣,《新华网》, 2007年4月22日, <http://finance.sina.com.cn/hy/20070422/22103526924.shtml>

¹⁴ 李克强在博鳌亚洲论坛 2014 年年会开幕式上的主旨演讲,《新华网》, 2014 年 4 月 10 日 http://www.gov.cn/guowuyuan/2014-04/11/content_2656979.htm

Хятад улс түүхийн урт хугацаанд Дэн Сяопин-ий дэвшүүлсэн “даруу байж, хүчээ нөөх” (韬光养晦) стратегийн үзэл баримтлалыг гадаад харилцааны үндсэн жолоодлого болгон, тууштай баримталж ирсэн юм. Энэхүү үзэл баримтлалын агуулга нь нэгд, дотоодын асуудлыг мөнхөд эн тэргүүнд тавих, “эдийн засгийн хөгжил бол хатуу ёс зүй юм”; хоёрт, гадаад харилцааны асуудлыг үндэсний эрх ашгийн үүднээс авч үзэх; гуравт, гадаад зөрчил маргаанд аль болох оролцохгүй байх; дөрөвт, тэсвэрлэх, хүлээнэх хандлагыг тэргүүн эгнээнд тавьж, хүч чадлаа зөв зохистой зарцуулах зэрэг дөрвөн үндсэн чиглэлтэй. Гэвч сүүлийн жилүүдэд олон улсын нөхцөл байдал улам нарийн төвөгтэй болж, даяаршил газар авч буй зэрэг хүчин зүйлсийн нөлөө хятадын гадаад харилцааны бодлогод гүн гүнзгий нэвтэрч, тусгалаа олж, хятад улс цаг үеийн нөхцөл байдалд тохирсон гадаад харилцааны бодлогын шинэчлэлт хийж эхэлсэн бөгөөд үүнийг Ши Жиньпин засгийн эрхэнд гарснаас хойш олон нийтэд хандсан үгэндээ “олон улсын хийгээд бүс нутгийн хэрэгт идэвхтэй оролцох” гэсэн ойлголтыг удаа дараалан дэвшүүлж, удирдан манлайлахыг эрмэлзэн, даян дэлхийг удирдан засах “удирдан чиглүүлэх” загвар бүхий гадаад харилцааны үзэл санааг бүрэлдүүлэхийг эрмэлзэж буйгаа байнга илэрхийлэх, мөн ХКН-ын 19-р их хурал зарлагдахын өмнө хятадын “ардын өдрийн сонин (renmin ribao) хийгээд Гадаад Харилцааны Яамны албан ёсны цахим хуудаснаа “ахиц дэвшлийн үүдийг нээх” (kaituo jinqu), “хичээл зүтгэлээ үргэлжлүүлэх” (fenfa youwei) зэрэг үг хэллэг ихэд ашиглагдах¹⁵ болсон зэргээс бэлхэн харж болно. Мөн Гадаад Харилцааны сайд Ван И Намын Сургуулиас эрхлэн гаргадаг “Шюэши таймс (Xuexi times)”-д Ши Жиньпин-ий гадаад харилцааны өнөөгийн үзэл баримтлалын үндсэн агуулгыг зургаан зүйлд хураангуйлан өгүүлэв. Үүнд (1) “Хятадын онцлогтой их гүрний гадаад харилцаа”-г хөгжүүлэх чиглэлийг тодорхой урагшлуулах; (2) “Хүн төрөлхтөний хувь заяаны цогц нэгдэл”-д хүрэх зорилгыг бататган бий болгох; (3) Хамтран ажиллаж, хамтдаа ялах цөм зарчим өөд тууштай тэмүүлэх; (4) Дэлхийн түншлэлийн харилцааны гол арга замыг нээн байгуулах; (5) Ашиг сонирхлын зөв үзэл баримтлалын үнэлэмжийн чиг баримжааг дэлгэрүүлэх; (6) “Нэг бүс нэг зам” их санаачлагыг дэвшүүлж, бий болгох зэрэг¹⁶; мөн 2018 оны 6 сард Бээжин хотод хуралдсан “ХКН-ын гадаад хэргийн хуралдаан” дээр Ши Жиньпин “харилцан бие биенээ хүндэтгэж, хамтран ажиллаж хамтдаа ялахыг үндэс болгож, энх тайван хөгжлийн замаар урагшлах”, “даян дэлхийг удирдан засах тогтолцооны өөрчлөлт шинэчлэлтэд идэвхтэй оролцох хийгээд удирдан залах”, “дэлхийн түншлэлийн харилцааны сүлжээг байгуулан, төгөлдөржүүлэх”¹⁷ зэрэг гадаад харилцааны арван үзэл баримтлалыг дэвшүүлжээ. Ши Жиньпин дотоодын хийгээд олон улсын төлөв байдлыг харгалзан, дэлхийн түншлэлийн харилцааг бий болгох талаар санал дэвшүүлж, нэгд, хөгжиж буй орнуудын түншлэлийн харилцааг тасралтгүй гүнзгийрүүлэх. Хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн хөгжлийн

¹⁵ 金灿荣：积极进取的中国外交有8个大变化，2018年03月08日，国际网，<http://comment.cfnisnet.com/2018/0308/1311712.html>

¹⁶ 王毅再提习近平外交思想 称超越西方300年，dw.com，2017年01月09日，<https://p.dw.com/p/2jEmV>

¹⁷ “十个坚持”理解习近平外交思想的一把金钥匙，求是网，2018年08月07日，http://www.qstheory.cn/international/2018-08/07/c_1123233747.htm

түвшин харилцан адилгүй тул даян дэлхийг удирдан засах механизмыг байгуулах, өөрчлөн шинэчлэх үйлс, цаашлаад бүс нутгийн асуудал хийгээд дэлхийн асуудлыг шийдвэрлэхэд гүйцэтгэх үүрэг, нөлөө нь ч адилгүй байх нь ойлгомжтой. Ши жиньпин-ий үзэж буйгаар аливаа улс орон том ч бай жижиг ч бай, бодит хүчин чадал их ч бай бага ч бүгд дэлхийн үйл хэрэгт эрх тэгш оролцох ёстой бөгөөд улс төрийн нэгдсэн ойлголцолд хүрэх зарчим дээр үндэслэн, хөгжиж буй улс орнуудын олон талт шинж хийгээд ялгаа зөрүүтэй шинжийг хамтын ажиллагааны хөгжлийн хөдөлгөгч хүч болгон хувиргаж, бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхийлэн урагшлуулж, хөгжиж буй улс орнуудын түншлэлийн харилцааг улам гүнзгийрүүлэн, хөгжлийн үр шимээс хамтдаа хүртэх явдлыг хэрэгжүүлэх; хоёрт, БРИКС-ийн хамтын ажиллагааны байгууллага болон холбогдох механизмийн үзүүлэх нөлөө, гүйцэтгэх үүргийг бүрэн дүрэн гаргаж, даян дэлхийн түншлэлийн харилцааг тасралтгүй өргөжүүлэх. БРИКС-ийн улс орнууд өнөөдрийг хүртэл төлөөлөх шинжтэй шинэ тутам хөгжиж буй эдийн засгийн хамтын ажиллагааны механизм болж чадсаны зэрэгцээ даян дэлхийн хэрэг явдлыг удирдан засах ажилд улам чухал үүрэг гүйцэтгэх болсон. Гэвч нөгөө талаас шинэ тутам хөгжиж буй хүч болохын хувьд одоо байгаа даян дэлхийн удирдан засах нөхцөл байдлыг өөрчлөхөд хүндрэлтэй хэвээр байгаа тул бусад улс орнуудын эрх ашиг хийгээд даян дэлхийн эрх ашгийг хамруулахад чадлын хэрээр зүтгэх хэрэгтэй байгаа юм”¹⁸ хэмээсэн нь хэрэв дээрхи хоёр ажлыг сайтар гүйцэтгэж чадваас улс орнуудын түншлэлийн харилцаа улам зузаарч, эв зохиролтой, энх тайванчаар зэрэгцэн орших нөхцөл бүрэлдэн бий болно хэмээн үзэв. Ийнхүү хятадын удирдагчдын илтгэлүүдийн агуулгад “хувь заяаны цогц нэгдэл”, “даян дэлхийн түншлэлийн харилцаа”, “даян дэлхийг удирдан засах тогтолцооны өөрчлөлт шинэчлэлтийг удирдан, оролцох” хийгээд “шинэ хэлбэрийн олон улсын харилцаанд хамтран ажиллаж, хамтдаа ялах” зэрэг үгс олонтаа хэрэглэгдэж байгаагаас даяаршлын үйл явц, үзэл санаа хятадын гадаад харилцааны бодлогод ямархан гүн гүнзгий нөлөөлж буйг, мөн хятадын шинэ засгийн засгийн газрын гадаад харилцааны бодлогын ерөнхий чиглэлийг харах боломжтой юм.

Ши Жиньпин 2013 онд “нэг бүс нэг зам” санаачлагыг дэвшүүлсэн мөчөөс эхлэн хятадын засгийн газар төрөл бүрийн судалгаа шинжилгээ, төлөвлөлтийн ажлыг эхлүүлсэн бөгөөд хамгийн анх 2015 оны 2 сард “нэг бүс нэг зам бүтээн байгуулалтын ажлын хуралдаан” –ыг зохион байгуулж, Үндэсний Хөгжил, Өөрчлөлт Шинэчлэлтийн Хорооны удирдлага доор нэг бүс нэг зам бүтээн байгуулалтын ажлыг урагшлуулах ажлын хэсгийг байгуулан, төрөл бүрийн бодлогын дүрэм журам боловсруулав. Чингээд 2015 оны 3 сард Хятадын Үндэсний Хөгжил, Өөрчлөлт Шинэчлэлтийн хороо, Гадаад Харилцааны яам, Худалдааны яам хамтран, “Торгоны замын эдийн засгийн бүс ба 21-р зууны торгоны замын зорилго, үйл ажиллагаа” хэмээх баримт бичиг тунхаглан гаргасан ба түүнд “нэг бүс, нэг зам”-ыг хамтдаа бүтээхүйн зорилго нь эдийн засгийн эд эсийг эмх цэгцтэй,

¹⁸ 韩跃民: 习近平关于全球治理的创新思想, 2017年12月29日 09:41 来源:《中国特色社会主义理论》http://foreignliterature.cssn.cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml

чөлөөтэйгөөр урсгах, нөөц баялгийг дээд зэргийн үр ашигтайгаар байршуулах, зах зээлүүдийг нягт холбох, зам дагуух олон улсын эдийн засгийн бодлогыг уялдуулах, илүү өргөн, илүү дээд, илүү гүнзгий шатны бүс нутгийн хамтын ажиллагааг өрнүүлэх, нээлттэй, хүртээмжтэй, тэнцвэртэй, ашигтай бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээг хамтдаа бүтээн байгуулах”-д оршино” хэмээн заахын зэрэгцээ торгоны замын эдийн засгийн бүсийн чухал хэсэг нь Хятадаас Төв Ази, Оросоор дамжин Европ (Балтийн тэнгис) хүрэх, Хятадаас Төв Ази, Баруун Азиар дамжин Персийн булан, Газар дундын тэнгис хүрэх, Хятадаас Зүүн өмнөд Ази, Өмнөд Ази, Энэтхэгийн далайд саадгүй хүрэх явдал хэмээн тодорхойлов. Мөн “Бодлогын уялдаа, дэд бүтцийн хэлхээ, худалдааны эргэлт, мөнгөний урсгал, хүмүүсийн ойлголцол зэрэг “Таван хэлхээ”(五通)-гээр илэрхийлэгдэх “хэлхээ холбоо” бол хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдлийн үндэс бөгөөд жинхэнэ “хүртээмжтэй даяаршил”-ыг хэрэгжүүлж, даяаршлыг түгээмэл тэнцвэртэй болгох агаад Хятадын олон үндэстнийг сэргэн мандуулах арга төдийгүй илүү олон улс орныг ядуурлаас ангижруулан чинээлэг болгох 21-р зууны бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны шинэ загвар юм” хэмээн тодорхойлсон байна.

Хятад улс нь нэг бүс нэг зам санаачлагыг бодитойгоор хэрэгжүүлэхэд тулгарах санхүүгийн асуудлыг шийдвэрлэх үүднээс олон талт хөгжлийн банкны загвар, зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг, Ази тивийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг голчлон дэмжих зорилготой Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк (АДБХОБ) байгуулсан ба энэ нь тэдний анхны санхүүгийн олон талт байгууллага юм. “Нэг бүс, нэг зам”-ыг хөгжүүлэх явцад АДБХОБ нь нэг талаар улс хоорондын улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх бөгөөд тус банкны өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа, олон улсын оролцоо, түүхэнд гүйцэтгэх үүрэг зэрэг онцлогоос нь харахад зам дагуух орнуудтай хамтын ажиллагааны чухал талбар, механизм болох нь илэрхий¹⁹ байна.

Дээр дурдсан Хятад улсын өнөөгийн гадаад харилцааны стратегиас харахад шинэ цагийн хятадын удирдагчид өмнө баримталсаар ирсэн “даруу байж, хүчээ нөөх” стратегитаа эрс шинэчлэлт хийж, дэлхийн хэмжээнд “хариуцлагатай улс гүрэн” байхад анхаарлаа хандуулж, олон улсын нийгэмд өдрөөс өдөрт нарийн төвөгтэй болж буй аюулгүй байдал, эдийн засаг хийгээд нийгмийн асуудалд дангаараа бус харин бусад улс орнуудтай хамтарч асуудалд хандан, шийдвэрлэхийг оролдох, хамтдаа үзэл бодол, хүсэл сонирхлоо нэгтгэн, хөгжлийн зүг хамтдаа алхан, зүтгэх гадаад харилцааны стратеги боловсруулан, ажиллахыг эрмэлзэж байна. Энэ нь тус улсын гадаад бодлогын онол хийгээд практикийн шинэчлэлтийн нэгэн гол чиг хандлага гэж хэлж болно. Мөн сүүлийн жилүүдэд хятадын удирдагчид “Хятадын мөрөөдөл”, “хоёр 100 жил” хэмээн удаа дараа дэвшүүлж байгаа нь хятадын хөрш орнуудтай харилцах стратеги зөвхөн тус улсын эдийн засгийн хөгжилд хандсан бус басхүү хятадын олон үндэстний аугаа их сэргэн мандалд

19 Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, УБ 2019 он, Удам Соёл хэвлэлийн газар

хүрэх их зорилгод үйлчилж, стратегийн зорилт нь өмнөх үеийн зорилтуудтайгаа харьцуулбал илэрхий өсч байгааг баталж байна.

Хятад улс намын 19-р их хурлаараа “Хятадын онцлогтой ‘их гүрэн’-ийг бүтээн байгуулах гадаад бодлого”-ыг дэвшүүлж, “бүхий л улс орнуудтай хамтдаа нэгэн замаар шинэ хэлбэрийн олон улсын харилцааг бий болгож, хамтдаа хүн төрөлхтөний хувь заяаны цогц нэгдлийг байгуулах” зэрэг гадаад харилцааны бодлогын зорилтыг чухалчилснаар урьд цагт өөрсдийгөө “хөгжиж буй” орон хэмээн тодотгодог байр сууриа эрс өөрчилж, харин эсрэгээрээ “хятадын онцлогтой их гүрний гадаад харилцааг байгуулах” гэдгээ товойлгон гаргаж байгаа зэрэг нь Хятад улс гадаад харилцааны байр суурины хувьд нэгэн шинэ өндөрлөг дээр зогсож байгааг илэрхий харуулж байна. Үүгээр зогсохгүй тэд өөрийн улсын байр суурийг “бүс нутгийн их гүрэн”-ээс “дэлхийн их гүрэн” болгон өөрчлөн дээшлүүлэв.

2. “Хувь заяаны цогц нэгдэл” ойлголтын тухай

Хятадын Ардын Их Сургуулийн профессор Тао Вэньжао хувь заяаны цогц нэгдлийг оновчтой стратегийн сэтгэлгээ (positive strategic thinking) хэмээн тодорхойлоод: “хувь заяаны цогц нэгдэл нь үнэн чанартаа цоо шинэ сэтгэлгээгээр дэлхийн стратегийг тунгаан бодох асуудал юм. Зөвхөн хамтран ажиллаж, хамтдаа ялж байж л их үйл хэрэг, сайн үйл хэрэг, урт настай үйл хэргийг бүтээж чадна. Нэг нь хожиж, нөгөө нь хохирдог, би ялж, чи ялагдах гэсэн хуучин сэтгэлгээг таядан хаяж, хоёр тал хоёулаа хожих, хамтдаа хожих шинэ үзэл санааг бий болгож, өөрийн эрх ашгийн төлөө зүтгэхдээ бусдын эрх ашгийг ч давхар бодолцон, өөрийн хөгжлийг эрэлхийлэхдээ ч хамтын хөгжлийг урагшлуулдаг байх ёстой”²⁰ хэмээн тэмдэглэсэн бол хятадын олон улс судлалын эрдэмтэн Лью Шипин “Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: Бүтээхүй хийгээд арга зам” хэмээх судалгааны бүтээл²¹-дээ: “ ‘хувь заяаны цогц нэгдэл’ гэдгийг энгийн үгээр илэрхийлбэл аливаа улс орон хатуу бэрхийг хамтдаа туулах харилцаагаар өөр зуураа холбогдох явдал юм. Үүнд зөвхөн эдийн засгаас гадна нийгэм, хүмүүнлэг, үнэт зүйл, аюулгүй байдлын цогц нэгдэл ч багтана” гэсэн бол хятадын Ардын их сургуулийн профессор, тэргүүлэх зэргийн судлаач Ван Ивэй: “Хувь заяаны цогц нэгдэл гэгч нь хүн төрөлхтний хамтын үнэт зүйлийн тухай санаа бөгөөд даяар нийтлэг гэх үнэт зүйлсээс халин давсан зүйл”²² гэж тодотгосон бол эрдэмтэн Хань Юймин: “хүн төрөлхтөний цогц нэгдэл” гэдэг нь хүн төрөлхтөн хамтдаа нүүр тулж буй даян дэлхийн нарийн төвөгтэй асуудлыг хамтдаа сөрж, шийдвэрлэхийн тулд санаачлагатайгаар бий болгосон харилцан хамааралтай, салгахын аргагүй, жаргал зовлонгоо хамтатган орших нэгэн шинэ хэлбэрийн харилцаа юм”²³ хэмээн тус тус

²⁰ Мөн дээрх

²¹ 陶文昭, 2016, 科学理解习近平命运共同体思想, 中国特色社会主义研究。http://www.zgtsshzy.net/CN/abstract/abstract415.shtml

²² Лью Шипин, орчуулсан Т.Чулуун-Эрдэнэ, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй ба арга зам, УБ, 2020 он, Соёмбо хэвлэлийн газар.

²³ Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, УБ 2019 он, Удам

тодорхойлжээ.

Хувь заяаны цогц нэгдэл бол Ши Жиньпин-ий засгийн газраас дэвшүүлсэн стратегийн чухал үзэл баримтлал юм. 2017 оны 1 сарын 18-ны өдөр Ши Жиньпин Швейцарьт “Хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдлийг зөвшилцөхүй, бүтээлцэхүй” дээд хэмжээний хуралд оролцох үеэрээ “Улс орнуудыг хүн төрөлхтний цогц нэгдлийг байгуулах агуу их үйл хэрэгт оролцож, яриа хэлэлцээгээр зөвшилцөн, хамт бүтээж, хамт хүртэн, хамтран ажиллаж хамтдаа хожин, туршлагаа хуваалцаж, ногоон эко хөгжлийн бодлого баримтлан, урт удаан энх тайван, түгээмэл аюулгүй байдал, хамтын хөгжил цэцэглэл, нээлттэй хүртээмжтэй, цэвэр цэмцгэр үзэсгэлэнт дэлхийг бүтээцгээе!”²⁴ хэмээн уриалсан билээ.

Тус ойлголт хэдийгээр намын 18-р их хурлаас хойш олны анхаарлыг татах болсон ч түүнийг дэвшүүлсэн хугацаа нь зөвхөн намын 18 их хурлаас үүдэлтэй биш юм. Аль 2007 онд ХКН-ын Ерөнхий Нарийн бичгийн даргын албан тушаал хашиж байсан нөхөр Ху Жинтао ХКН-ын Бүх Хятадын төлөөлөгчдийн их хурал дээр тавьсан илтгэлдээ “хувь заяаны цогц нэгдэл” хэмээх ойлголтыг албан ёсоор дэвшүүлж, тухайн үед тэрээр энэхүү ойлголтоороо Хятадын эх газар хийгээд Тайван хоорондын хоёр эргийн онцгой харилцааны талаар дүрслэн өгүүлжээ²⁵. 2011 онд «Хятадын энх тайван хөгжил цагаан ном»-нд “хувь заяаны цогц нэгдэл”-ийг хүн төрөлхтний эрх ашиг болон хамтын үнэ цэнийн шинэ ойлголтыг шинэ харах өнцгөөс эрж хайх хэрэгтэй хэмээн дэвшүүлэв. 2013 оны 4 сард Боагийн Азийн чуулга уулзалтад оролцох үеэрээ Ши Жиньпин гол илтгэлдээ “Хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй, улс орнууд нэг дэлхий дээр оршиж байна. Хамтын хөгжил бол тогтвортой хөгжлийн чухал үндэс бөгөөд улс түмний өнө холын эрх ашиг, үндсэн ашиг сонирхолд нийцэж байна. Бид нэгэн бөмбөрцөг хотхон дээр аж төрөхдөө нийтлэг хувь заяаны цогц нэгдлийн үзэл ухамсрыг бат бэх бүрдүүлж, цаг үеийн чиг урсгалтай хөл нийлүүлэн, зөв чиг шугам баримтлан, жаргал зовлонгоо хуваалцан, Ази тив болон дэлхийн хөгжил шинэ шатанд дэвшихэд тус дөхөм үзүүлэх ёстой” хэмээн онцлон тэмдэглэв²⁶. Харин 9 сард нь “20-ийн бүлэг”-ийн гишүүн орнуудын удирдагчдын 8 дахь удаагийн дээд хэмжээний уулзалт дээр Ши Жиньпин “Улс орнууд хувь заяаны нийтлэг цогц нэгдлийн ухамсарыг төлөвшүүлэн, “нэг нь сайн аваас нийтээрээ сайн байх, нэг нь саар аваас нийтээрээ саар байх” холбоо хамаарлын үр нөлөөг жинхэнээр нь таних ёстой”²⁷, мөн 2014 оны Намын Төв Хорооны хуралдаан дээр “Хөрш зэргэлдээ орнуудтай гадаад харилцаагаа сайтар явуулж, хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдлийг бүрдүүлэн,

Соёл хэвлэлийн газар

²⁴ 韩跃民：习近平关于全球治理的创新思想，2017年12月29日 09:41 来源：《中国特色社会主义理论》http://foreignliterature.cssn.cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml

²⁵ Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, УБ 2019 он, Удам Соёл хэвлэлийн газар

²⁶ 胡锦涛在中共第十七次全国代表大会上的报告全文, 新华社, 北京, 2007年10月24日电, <http://www.lswz.gov.cn/html/zhuanti/17da/200710261-10.html>

²⁷ 博鳌亚洲论坛2013年会开幕 习近平发表主旨演讲, 中央政府门户网站 www.gov.cn, 2013年4月7日, http://www.gov.cn/ldhd/2013-04/07/content_2371488.htm

ойр дотно, чин сэтгэлийн, харилцан ашигтай, уужуу хүртээмжтэй байх хөрш орны бодлого баримтлан, хөрштэйгөө найрсаг, хөрштэйгөө түнш байж, найрсаг хөрш, амгалан хөрш, баян хөрш бодлогын дагуу хөрш орнуудтайгаа харилцан ашигтай хамтран ажиллаж, хэлхээ холбоогоо гүнзгийрүүлэх ёстой”²⁸ хэмээн тус тус цохон тэмдэглэжээ.

XX зууны 90 оноос хойш даян дэлхийг удирдан засах нөхцөл байдал хийгээд дэлхийн эрх мэдлийн бүтцэд томоохон өөрчлөлт орж, нэг талаас олон улсын байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага хийгээд төрийн бус үйл ажиллагаа эрхлэгчид олноор төрөн гарч, энэ нь улс орнуудын бүрэн эрх, байр суурийг тодорхой хэмжээнд ганхуулан, хүндрэл бэрхшээлтэй дагуулав. Жишээ нь олон улсын эдийн засгийн дэг журмыг тогтоох, улс орны эдийн засгийн гадаад шинжтэй асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч, Дэлхийн Худалдааны Байгууллага, 20-ийн бүлэг зэрэг олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийг удирдан засах гол бүтэц болсон байна; нөгөө талаас шинэ тутам хөгжиж буй аж үйлдвэр хийгээд хөгжиж буй орнуудын сэргэн мандал нь урьдны даян дэлхийн эрх мэдлийн бүтэц өөрчлөгдөхөд нөлөөлж, олон улсын асуудлыг шийдвэрлэхэд шинэ хөдөлгөгч хүч, шинэ эрч хүчийг нэмжээ. Жишээ нь БРИКС, Хятад-АСЕАН, Хятад Африкийн хамтын ажиллагааны форум, Хятад Африкийн хөгжлийн сан зэрэг хөгжиж буй улс орнуудын хамтын ажиллагааны байгууллага тасралтгүй төрөн гарсаар. Гэвч үүний зэрэгцээ хөгжиж буй олон улс орон даян дэлхийн удирдан засах дүрэм журам боловсруулах үйл хэрэг хийгээд үг хэлэх эрхийн тал дээр асуудлын захад хаягдах байдал байсаар, үүний тухай Ши Жиньпин: “Даян дэлхийг удирдан засахдаа ‘эрх тэгш байдлыг үндэс болгож, дэлхийн эдийн засгийн өнөөгийн шинэ бодит байдалтай нүүр тулахдаа илүү сайн эргэцүүлэн бодож, шинэ тутам хөгжиж буй зах зээлийн улс орнууд хийгээд хөгжиж буй улс орнуудын төлөөлөх шинж, үг хэлэх эрхийг нь нэмэгдүүлж, улс орон бүрийн олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа дахь эрх мэдлийн эрх тэгш байдал, боломжийн эрх тэгш байдал, дүрэм журмын эрх тэгш байдлыг баталгаажуулах ёстой” хэмээн тодорхой заажээ²⁹.

Эдүгээ Хятад улс хөрш зэргэлдээ холбогдох улс орнуудтай одоо байгаа хоёр ба олон талт механизмд түшиглэн, бүс нутгийн үр дүнтэй хамтын ажиллагааны платформыг бий болгохыг зорьж, “эртний ‘торгоны зам’-ын түүхэн загварыг хэрэглэн, энх тайвныг бэхжүүлж, улс орнууд эдийн засгийн хамтын ажиллагааны түншлэлээ идэвхтэй хөгжүүлж, үүний үр дүнд улс төрийн итгэлцэл, эдийн засгийн интеграц, соёлын хүртээмжтэй байдлыг агуулсан ашиг сонирхол, хариуцлага, хувь заяаны цогц нэгдлийг бий болгоно”³⁰ хэмээн олонтаа санал дэвшүүлсээр байна. Эртний торгоны зам худалдаа арилжааны хамтын ажиллагаа, соёлын харилцаа, үндэстний тогтвортой байдал хэмээх гурван талд идэвхитэй үүрэг гүйцэтгэж

²⁸ 习近平在G20峰会第一阶段会议上的发言(全文, 中央政府门户网站http://www.gov.cn/ldhd/2013-09/06/content_2482284.htm

²⁹ 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2014.

³⁰ 韩跃民: 习近平关于全球治理的创新思想, 2017年12月29日 09:41 来源:《中国特色社会主义理论》http://foreignliterature.cssn.cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml

байсан бол өнөөдрийн “нэг бүс нэг зам” санаачлага ч мөн эртний торгоны замын эл гурван өвөрмөц үүргийг гаргаж буй юм³¹

Хятадын Ардын их сургуулийн профессор, ХКН-ын Төв Хорооны дэргэдэх орчин үеийн дэлхий судлалын төвийн тусгай судлаач, “Нэг бүс, нэг зам”-ын тэргүүлэх судлаач Ван Ивэй “Нэг бүс, нэг зам: Хятадын өсөлт, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага номондоо³²: Хятад улсын хувьд хөрш зэргэлдээ эргэн тойрон гэдэг нь аюулгүй байдлын амин чухал газар, цэцэглэн хөгжих үндэс суурь болсон газар юм. Иргэний нийгэмтэй холбоотой түүхэн үзэл баримтлалд үндэслэн “Нэг бүс, нэг зам” нь соёл иргэншлийн цогц нэгдлийн үзэл баримтлалд суурилан, даяаршил, Евразийн интеграцын стратегийн дагуу Хятадын эргэн тойрны их орчинд эрх ашиг, үүрэг хариуцлага, аюулгүй байдлын цогц нэгдлийг төлөвшүүлэн, эцэстээ хувь заяаны цогц нэгдлийг бүтээн байгуулах замаар Хятадын олон улс дахь нөлөө, зөөлөн хүчийг нэмэгдүүлэх болно” хэмээн хятадын гадаад улс орнуудтай харилцах бодлого стратегийг маш тод томруун өгүүлсэн байдаг.

“Нэг бүс, нэг зам”-ын үзэл санааны эрхэм зорилт хэдийн олон улсад хүлээн зөвшөөрөгдөөд байгаа билээ. 2017 оны 1 сарын 10-ны өдөр НҮБ-ын Нийгмийн Хөгжлийн Хорооноос “Африкийн хөгжлийн шинэ түншлэлийн нийгэм” гэх шийдвэрийг баталж, олон улсын хамтын нийгэмлэгийг “хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх ойлголтоор Африк тивийн нийгэм эдийн засгийн хөгжилд туслахыг уриалсан бөгөөд ингэснээр “хүн төрөлхтний хувь заяаны цогц нэгдэл” хэмээх томъёолол анх удаа НҮБ-ын шийдвэрт бичигдсэн юм. Энэ бол уг үзэл санаа хамтын хөгжлийн алсын зорилго болохынхоо хувьд өргөн дэмжлэг хүртэж буйг илтгэж буй хэрэг.

Хятадын эрдэмтэд “хувь заяаны цогц нэгдэл”-ийг дэвшүүлэх болсон түүхэн нөхцлийг дүгнэхдээ, нэгд, дэлхийн олон туйлт үзэгдэл, эдийн засгийн даяаршил, нийгмийн мэдээлэлжилт өдрөөс өдөрт гүнзгийрч, улс хоорондын харилцааны бүтцийн онцлог улам бүр тодорч буй; хоёрт, даян дэлхийн шинжтэй асуудлууд өдрөөс өдөрт товойн гарч, улс орнууд хамтын засаглалын чадвараа бэхжүүлэх шаардлагатай болсон; түүнчлэн “хувь заяаны цогц нэгдэл” дэвшүүлсэн нь “хятадын мөрөөдөл”-ийг биелүүлэх хийгээд хятад улсын дүр төрхийг сайжруулах лугаа нягт холбоотой; Хятадыг “хариуцлагатай их гүрэн”-ий дүр төрхийг бүрдүүлэн, хамгаалахад ихээхэн тус дэмтэй³³ хэмээн үзэж байна. Ши Жиньпин 2015 оны 9 сарын 28-нд болсон НҮБ-ын 17 дахь удаагийн хуралд хэлсэн үгэндээ ч: “Дэлхийн байдал эдүгээ түргэн хурдацтай хувиран өөрчлөгдөж буй түүхэн үйл явцын дунд оршиж байна. Энх тайван, хөгжил, дэвшлийн нарны гэрэл дайн, ядуурал, хоцрогдлын харанхуй мананг нэвт гийгүүлж байна. Дэлхийн олон туйлт байдал улам бүр хөгжиж, зах зээл шинээр хөгжиж буй орнууд болон хөгжиж буй орнуудын

³¹ Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, УБ 2019 он, Удам Соёл хэвлэлийн газар

³² 王义桅, 2015, “一代一路” 机遇与挑战, 人民出版社

³³ Ван Ивэй, “Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх үүрэг хариуцлага, УБ 2019 он, Удам Соёл хэвлэлийн газар

сэргэн мандал тогтоон барихын аргагүй түүхийн урсгал болоод байна. Эдийн засгийн даяаршил, нийгмийн мэдээлэлжилт нь нийгмийн үйлдвэрлэх хүчнийг туйлын ихээр чөлөөлж хөгжүүлэн, урьд өмнө байгаагүй хөгжлийн боломжийг нээхийн зэрэгцээ, ул суурьтай хандах ёстой шинэ аюул, шинэ сорилтыг дагуулж байна”³⁴ хэмээн өнөөгийн дэлхий дахинд олон асуудал, сорил, боломж төрөн гарч буйг онцолжээ.

Эдүгээ эдийн засгийн даяаршлын үйл явц улам гүнзгийрч буйг даган, үндэстэн улсын хаалт, хориг аажим аажмаар арилж, хүн төрөлхтөний нийгмийн амьдралын харилцан хамаарал урьд байгаагүйгээр нэмэгдэн, “хүн төрөлхтөний хамтын эрх ашиг өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, түүнтэй холбогдох эрх ашгийн хэлбэр бүрэлдэн бий болоод байна”. Олон улсыг хамарсан эрсдэл хийгээд даян дэлхийн шинжтэй асуудалтай нүүр тулахад даян дэлхийн шинжтэй хариуцлагын ухамсар суух хэрэгтэй талаар Ши Жиньпин: “Бид сорилтоор дүүрэн дэлхий ертөнцөд аж төрж байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт шинэ хөдөлгөгч хүчийг, дэлхийн хөгжил олон нийтэд илүү тустай тэнцвэрт байдлыг үгүйлж, баян ядуугийн ялгааны зааг хязгаарыг хумиж багасгах шаардлагатай байна. Бүс нутгийн халуун цэгүүдийн ороо бусгаа байдал даамжирч, терроризмын дур зоргоороо авирлах нь гаарч байна. Энх тайвны алдагдал, хөгжлийн алдагдал, засан тохинуулах үйл хэргийн алдагдал бол хүн төрөлхтөний өмнө тулгарч буй ноцтой сорилт мөн”³⁵ хэмээгээд даян дэлхийн аюул занал, асуудал олноор үүсч байгаа тул үндэстэн, улс орон бүгд өөрийн эрх ашгийн төлөө хичээн зүтгэхийн зэрэгцээ хүн төрөлхтөний оршин тогтнох хийгээд хөгжих, энх тайван хийгээд аюулгүй орших нөхцөл, орчин зэрэг талуудын хамтын эрх ашгийг хамгаалах талаар бодолцох ёстой цаг үед ирээд байна”³⁶ хэмээв. Ийнхүү даяаршлын эрч өдрөөс өдөрт нэмэгдэж, улс орнуудын харилцан хамаарлын түвшин өндөрсөж, аливаа нэгэн улс даяаршлын нөлөөнд үүссэн асуудлыг дангаар шийдвэрлэх боломжгүй болж байгаа тул хувь заяаны цогц нэгдлийг цогцлоох ажлыг илүүтэй шуурхай гүйцэтгэх эрч хүч болж байна хэмээн хятадын судлаач, эрдэмтэд үзэж байна. Жишээ нь Азийн улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарлын хэмжээ улам өсөх хандлагатай болж, Олон улсын Вальютын Сан (ОУВС)-гаас гаргасан тоон үзүүлэлтээр 2008 онд олон улсын санхүүгийн хямрал болсноос хойш 5 жилийн хугацаанд Азийн дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн хувь нэмэр нь 2/3-д хүрсэн ... Азийн бүс нутгийн дотоодын худалдаа 21-р зууны эхэн үеийн 800 тэрбум ам доллараас хэдийнээ 3 их наяд ам долларт хүрсэн нь худалдааны харилцан хамаарлын хэмжээ 50%-ийг давсан³⁷-ыг харуулж байна.

“Хувь заяаны цогц нэгдэл” нь хатуу, зөөлөн хоёр талтай буюу эхнийх нь арга хэмжээ, удаахи нь үзэл баримтлалыг хэлж буй. Арга хэмжээ гэдэгт “тууштай баримтлах дөрвөн зүйл” буюу харилцан хүндэтгэх, эрх тэгш хандах; хамтран

³⁴ 李海龙, 中国外交新理念: 倡导“命运共同体”的建设, 2014年, 陕西行政学院学报, 5期, 28(2).

³⁵ 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2017.

³⁶ 习近平, 习近平谈治国理政 第二册, 外文出版社, 2017.

³⁷ 韩跃民: 习近平关于全球治理的创新思想, 2017年12月29日 09:41 来源:《中国特色社会主义理论》http://foreignliterature.cssn.cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml

ажиллаж хамтдаа ялах, хамтдаа хөгжих явдлыг тууштай баримтлах; хамтын, цогц, хамтарсан, тогтвортой аюулгүй байдлыг тууштай баримтлах; өөр өөр соёл иргэншлийг тэгш хамарсан, харилцан суралцах явдлыг баримтлах; харин үзэл баримтлалын тухайгад хувь заяаны цогц нэгдлийн тухай ойлголтыг хөрш зэргэлдээ улс орнуудад суулгах явдал юм хэмээн үзэж байна. Энэ тухай Ши Жиньпин хэлэхдээ “хөрш зэргэлдээ улс орнуудад хувь заяаны цогц нэгдлийн ухамсрыг гүн бат суулгах” ёстойг онцлоод, хувь заяаны цогц нэгдэл нь арга хэмжээнээс гадна үзэл баримтлалтай байх хэрэгтэй. Энэ хоёр нь харилцан бие биедээ тулгуурлан оршиж, харилцан бие биедээ түлхэц өгч, урагшлуулах ёстой хэмээн заажээ. Ши Жиньпин Ази номхон далайн бүс нутгийн хуралдаан дээр: “Ази, Номхон далайн бүс нутгийн нийтлэг хувь заяаны цогц нэгдлийн үзэл ухамсрыг баттай тогтоож, өөрийн хөгжлөөр бусдын хөгжлийг хөтлөн, уялдуулан зохицуулах, хамтран ажиллах замаар өөр өөрсдийн давуу талаа хамгийн дээд зэргээр илтгэн, зөв эрч хүчийг бий болгон, эдийн засгийн цогцуудын харилцан ажиллагаа, зохицуулалттай сайн хөгжлийн нөхцөл байдлыг бүрдүүлэх ёстой”³⁸ хэмээн тэмдэглэн хэлжээ. Энэ бүхнээс харахад Хятад улс хувь заяаны цогц нэгдэл хэмээх үзэл баримтлалыг гадаад харилцааны бодлогын туйлын мөрдлөг болгож, тууштай баримтлах чиг хандлагтай байгаа нь илт байна.

“Хувь заяаны цогц нэгдэл” санаачилгыг дэвшүүлэхэд хүргэсэн хөшүүргийн талаар эрдэмтэд: “Үндсэн хоёр хөдөлгөгч хүч бий. Нэгд, богино хугацаанд энэхүү ойлголтоор дамжуулан, хятадын засгийн газар хөрш орнуудтайгаа Өмнөд Хятадын Тэнгис дэх газар нутгийн маргаантай асуудлыг намжаан, холбогдох улс орнуудтай гадаад харилцаагаа зөөлрүүлэх; хоёрт XXI зууны эхний 20-30 жил буюу хятадын “стратегийн боломжит үе” (机遇期)-дээ энэхүү санаачлагыг чиг баримжаа хийн, гадаад харилцааны стратегиа сайтар хэрэгжүүлж, хятадын эдийн засгийн хөгжилд гадаад харилцааны таатай орчныг бий болгохыг эрмэлзэж буй”³⁹ хэмээн үзэж байна. Энэхүү хөшүүргийг ашиглан, Хятад улс хөрш зэргэлдээ улс орнуудын дэмжлэгийг авахын тулд улс орнуудтай маш хүчирхэг, хамтын эрх ашиг цогцолсон зангилааг бий болгохоор чармайж байна. Тиймээс ч хүчирхэг эдийн засаг, бодит чадамждаа тулгаарлан, хятад улс хөрш зэргэлдээ түнш орнууддаа эдийн засгийн таатай боломжуудыг илт санал болгосоор байгаа юм. Жишээ нь 2018 онд Хятад улс “нэг бүс нэг зам” дагуух 56 улс орнуудад хийсэн санхүүгийн бус төрлийн шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээ 15,64 тэрбум ам доллар хүртэл өсгөсөн нь өнгөрсөн жилтэй нь харьцуулбал 8,9%-иар өссөн, үүнд гол нь Сингапур, Лаос, Вьетнам, Индонези, Пакистан, Малайз, Орос, Камбочи, Тайланд хийгээд Аргентин зэрэг улс багтсан⁴⁰, мөн 2014 онд Хятад-Африк хоёр талын худалдаа 220 тэрбум ам доллараас хэтэрч,

³⁸ Лью Шипин, орчуулсан Т.Чулуун-Эрдэнэ, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл: бүтээхүй ба арга зам, УБ, 2020 он, Соёмбо хэвлэлийн газар.

³⁹ 习近平: 弘扬传统友好 共谱合作新篇, 2014年07月18日, <http://www.scio.gov.cn/31773/31774/31783/Document/1396197/1396197.htm>

⁴⁰ Denghua Zhang, The Concept of ‘Community of Common Destiny’ in China’s Diplomacy: Meaning, Motives and Implications, 2017, Received: 30 October 2017 | Revised: 25 January 2018 | Accepted: 1 March 2018 Asia & the Pacific Policy Studies, vol. 5, no. 2, pp. 196–207 doi: 10.1002/app5.231.

2000 оныхтой харьцуулахад 22 дахин өссөн байна. Африк улс Хятадын дэмжлэгийг хамгийн их хүртэгч орон бөгөөд 2010-2012 оны хооронд тэд дэлхийн 121 улс оронд тусламж үзүүлснээс Азийн 30 орон, Африкийн 51 орон, Номхон далай дахь арлуудын 9 орон, Латин Америк болон Карибын тэнгисийн 19 орон, Европын 12 улс орнуудад тус тус тусламж өгсөнөөс Африкт нийт 6,65 тэрбум ам доллар буюу Хятадын гадаад нийт тусламжийн 51.8% оноогдсон⁴¹ зэрэг олон жишээ баримтыг дурдаж болох юм.

Дээр дурдсан хятадын шинэ засгийн газрын удирдагчдын хэлсэн үг, дэвшүүлсэн санал санаачлага, баримт бичиг, албан ёсны мэдэгдэл хийгээд эрдэмтэн судлаачдын хийсэн холбогдох судалгаа зэргээс харахад эрх тэгш, харилцан итгэлцсэн шинэ хэлбэрийн эрх мэдлийн үзэл баримтлал, хамтран ажиллаж, хамтдаа ялах хамтын эрх ашгийн үзэл баримтлал болон уужуу хүртээмжтэй, бие биенээсээ суралсан соёл иргэншлийн үзэл баримтлал бүгд нийлээд хятад улсын дэвшүүлж буй “хувь заяаны цогц нэгдэл” хэмээх ойлголтын үндсэн агуулга нь болох юм гэж дүгнэж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Ши Жиньпин засгийн эрхэнд гарснаас хойш гадаад харилцаандаа идэвхтэй, санаачлагатай нээлттэй байх стратегийг илүүтэй баримталж, харилцан ашигтай, хамтдаа ялсан, олон талт тэнцвэртэй, аюулгүй өндөр үр ашиг бүхий нээлттэй хэлбэрийн эдийн засгийн тогтолцоог төгөлдөржүүлэх бодлогыг түлхүү авч хэрэгжүүлэн, харин гадагшаа хандсан хөгжлийн тал дээр “хувь заяаны цогц нэгдэл” үзэл баримтлалыг бодлогын гол шугам болгож байна.

Хувь заяаны цогц нэгдэл бол Ши Жиньпин-ий засгийн газраас дэвшүүлсэн стратегийн чухал үзэл баримтлал юм. Энэхүү шинэ ойлголт нь эрх тэгш харилцан итгэлцэх шинэ хэлбэрийн эрх мэдлийн үзэл баримтлал, хамтран ажиллаж хамтдаа ялах хамтын эрх ашгийн үзэл баримтлал, уужуу хүртээмжтэй харилцан суралцах соёл иргэншлийн үзэл баримтлал зэрэг өргөн агуулгатай юм. Хятад улс “хувь заяаны цогц нэгдэл” үзэл баримтлалаар дамжуулан, бусад улс орнуудтай, тэр дундаа хөрш зэргэлдээ орнуудтай хамтран ажиллаж, хамтдаа ялах нээлттэй стратегийг цаашид үргэлжлүүлэн баримталж, худалдаа хийгээд хөрөнгө оруулалтыг чөлөөтэй байлгах, амар хялбар байх явдлыг урагшлуулахыг уриалан, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх замаар дэлхийн эдийн засгийн чадал чансаа, тогтвортой энх тайван, тэнцвэртэй өсөлтийг урагшлуулах бодлогыг барин ажиллаж байна. Манай улсын хувьд хөрш гүрний дэвшүүлж буй энэхүү гадаад харилцааны шинэ жанжин шугам, чиг хандлагыг шинжлэх ухаанчаар судалж, утга агуулгыг бүрэн тайлж, ухан ойлгох нь маш чухалтай байна.

⁴¹ 李佳、鲁佩等，2019，一带一路从规划到落地，装备出海大势所趋，华创证券，机械设备行业周报，证监会审核华创证券投资咨询业务资格批文号：证监许可（2009）1210号

НОМЗҮЙ

- Шипин Лью, Хятад улс ба хөрш орнуудын хувь заяаны цогц нэгдэл:
бүтээхүй ба арга зам. УБ, 2020 он. орч. Чулуун-Эрдэнэ.Т.
- Ивэй Ван.“Нэг бүс нэг зам”: Хятадын сэргэн мандал, тэнгэрийн доорх
үүрэг хариуцлага. УБ, 2019 он.
- 王义桅. “一代一路” 机遇与挑战, 人民出版社. 2015.
- 习近平. 习近平谈治国理政. 第一册. 外文出版社. 2014.
- 习近平. 习近平谈治国理政. 第二册, 外文出版社. 2017.
- Zhang, Denghua. “The Concept of ‘Community of Common Destiny’ in
China’s Diplomacy: Meaning, Motives and Implications.” *Asia & the
Pacific Policy Studies*, vol. 5, no. 2 2017, (March 2018): 196–207. doi:
10.1002/app5.231.
- Medeiros, S. Evan and Fravel, M. Taylor. “China’s New Diplomacy,” *Foreign
Affairs*, 82:6 (2003): p.22.
- Sutter, G. Robert. “Chinese Foreign Relations: Power and Policy since the Cold
War”. p.261, Maryland: Rowman & Littlefield, Inc., 2008.
- Lum, Thomas, et al. “China’s “Soft Power” in Southeast Asia.” (Washington,
D.C.: U.S. Senate Committee of Foreign Relations, 2008), p.2.
- 博鳌亚洲论坛2013年会开幕 习近平发表主旨演讲, 中央政府门户网
站www.gov.cn, 2013年4月7日, http://www.gov.cn/lhdh/2013-04/07/content_2371488.htm
- 高举邓小平理论伟大旗帜, 把建设有中国特色社会主义事业全面推向二
十一世纪(2) —江泽民在中国共产党第十五次全国代表大会上的报
告, 人民网, 1997年9月12日;
- 韩跃民: 习近平关于全球治理的创新思想, 2017年12月29日 09:41 来
源: 《中国特色社会主义理论》[http://foreignliterature.cssn.
cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml](http://foreignliterature.cssn.cn/mkszy/201712/t20171229_3799196_4.shtml)
- 胡锦涛在亚非峰会上的讲话全文, 新华网, 2005年4月22日; [http://
news.sina.com.cn/w/2005-04-22/18355725062s.shtml](http://news.sina.com.cn/w/2005-04-22/18355725062s.shtml)
- 胡锦涛在中共第十七次全国代表大会上的报告全文, 新华社,
北京, 2007年10月24日电, [http://www.lswz.gov.cn/html/
zhuanti/17da/200710261-10.html](http://www.lswz.gov.cn/html/zhuanti/17da/200710261-10.html)
- 江泽民同志在党的十六大上所作报告全文, 2002年11月18日, [https://
www.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zyjh_674906/t10855.shtml](https://www.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zyjh_674906/t10855.shtml)
- 金灿荣: 积极进取
- 李佳、鲁佩等, 2019, 一带一路从规划到落地, 装备出海大势所趋, 华
创证券, 机械设备行业周报, 证监会审核华创证券投资咨询业务资
格批文号: 证监许可(2009)1210号[http://pdf.dfcfw.com/pdf/
H3_AP201904301324685563_1.pdf](http://pdf.dfcfw.com/pdf/H3_AP201904301324685563_1.pdf)
- 李克强在博鳌亚洲论坛 2014 年前会开幕式上的主旨演讲, 《新华网》
, 2014 年 4 月 10 日[http://www.gov.cn/guowuyuan/2014-04/11/
content_2656979.htm](http://www.gov.cn/guowuyuan/2014-04/11/content_2656979.htm)
- 王毅再提习近平外交思想 称超越西方300年, dw.com, 2017年01月09
日, <https://p.dw.com/p/2jEmV>
- “十个坚持” 理解习近平外交思想的一把金钥匙, 求是网, 2018
年08月07日, [http://www.qstheory.cn/international/2018-
08/07/c_1123233747.htm](http://www.qstheory.cn/international/2018-08/07/c_1123233747.htm)
- 中国外交有8个大变化, 2018年03月08日, 国际网, [http://comment.
cfisnet.com/2018/0308/1311712.html](http://comment.cfisnet.com/2018/0308/1311712.html)
- 中国提出新型亚洲引起共鸣, 《新华网》, 2007 年 4 月 22 日, <http://>

finance.sina.com.cn/hy/20070422/22103526924.shtml
习近平：弘扬传统友好 共谱合作新篇，2014年07月18日，<http://www.scio.gov.cn/31773/31774/31783/Document/1396197/1396197.htm>
习近平在G20峰会第一阶段会议上的发言（全文，中央政府门户网站
http://www.gov.cn/lhdh/2013-09/06/content_2482284.htm
新华社北京7月10日电 国务院新闻办公室10日发表《中国的
对外援助（2014）》白皮书。全文。http://www.gov.cn/zhengce/2014-07/10/content_2715467.htm